



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№31 /245/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.02.15

Цаг үе, үйл явдал

БХЯ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАЙЛАГНАВ



БХЯ-ны 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурал өнөөдөр боллоо. Тайлангийн хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг болон БХЯ-ны бие бүрэлдэхүүн оролцлоо. БХЯ-ны 2021 оны үйл ажиллагааны тайланг СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандивраа танилцуулсан

бол яамны 2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг ХШУДАГ-ын дарга хурандаа Б.Эрхэмбаяр нар тус тус танилцууллаа. Үүний дараа БХЯ-ны 2021 оны тэргүүний газар, хэлтэс, ажилтан алба хаагчдад шагналыг нь гардуулсан юм. Төгсгөлд нь Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БХЯ-ны бие бүрэлдэхүүнд хандаж зарим үүрэг чиглэлийг өгөв.



“ГЭР БҮЛИЙН ЗӨВЛӨЛ” БАЙГУУЛНА



ЗХЖШ болон Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газртай цаашид хэрхэн хамтран ажиллах талаар уулзалтыг зохион байгуулав. Тус уулзалтад ЗХЖШ-ын ахлагч тэргүүн ахлагч Н.Баасан, ХЗЦК-ын ахлагч тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр нар оролцсон бөгөөд ЗХЖШ, Хуурай замын цэргийн командлал болоод анги, нэгтгэлүүдэд “Гэр бүлийн зөвлөл” байгуулах, хугацаат цэргийн албаны байлдагчдад ур чадвар олгох сургалт зохион байгуулах, залуу офицер, ахлагчдад гэр бүл төлөвлөлт болон гэр бүлийн тогтвортой байдлын талаарх сургалт, нөлөөллийн ажил шат

дараатай зохион байгуулах мөн алба хаагчдын хүүхдэд зориулсан хөгжил, хамгааллын үйлчилгээг зохион байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулах, хамтран ажиллах талаар санал солилцлоо. Өнгөрөгч 2020-2021 онд гэр бүлийн боловсрол, хүүхдийн эрх хамгааллын талаар цуврал сургалтууд, гэр бүлд сэтгэл зүйн болон эрх зүйн зөвлөгөө өгч, ковид 19 цар тахлын үед дэмжлэг шаардлагатай гэр бүлүүдэд тусламж дэмжлэг үзүүлэх, залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил, амьдрах ухааны ур чадвар олгох зэрэг ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулж хамтран ажилласан юм.

ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БНФУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сибастиян Сүрүнийг өнөөдөр хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар Монгол, Франц Улсын Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, цаашид өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх

арга хэмжээний талаар санал солилцов. Түүнчлэн 2014 онд байгуулсан “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, БНФУ-ын Батлан хамгаалах яам хоорондын техникийн тохиролцоо”-хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хамтын ажиллагааны төрөл, чиглэлийг нэмэгдүүлэх асуудалд санал нэгдэв.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,270,478 /69.8%/	2,171,771 /66.8%/	ЗХЖШ 31,0% 91,419 /2,8%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8146 +112	123	7906

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 414,014,031
Эдгэрсэн	Нийт: 336,056,866
Нас барсан	Нийт: 5,844,966

Түүхэнд энэ өдөр

1936 он. Японы халдан довтлогчдыг гарамгай хүмүүсийг сайшаан тухай Яамны сайд, Бүх цэргийн жанжны 18 тоот тушаал гарав.

1961 он. БНМАУ-ын Зөвлөлийн 58 дугаар Батлан Хамгаалах Нийгэмлэгийг /БХХН/ байгуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-33

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,861.00	2,864.0
EUR	3,240.0	3,255.0
CNY	450.00	451.00
RUB	37.40	38.20
JPY	24.73	24.85
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ

2022.02.15 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 14/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал: Эд мал арвидна НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.59-18.14 Барилдлага: Үхэх ШҮТЭН БАРИЛДЛАГА: Төрөн түгэхүй Суудал: Огторгуй

Энэ өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг мүүд нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хараал, жатхыг буцаах, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

Цахим шууданд

30 КМ-ЫН ЯВГАН МАРШИЙГ ҮЙЛДЛЭЭ



Зэвсэгт хүчний 189 дүгээр анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нарын үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх, сургалт бэлтгэлийг эрчимжүүлэх, сэтгэл зүйн болон бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор 30 км-ийн явган маршийг энэ сарын

9-ний өдөр ангийн байрлал-ҮБХИС-ийн сургалтын төв-Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн засвар хангалтын төвийн буудлагын полигон-ангийн байрлал гэсэн чиглэлд зохион байгууллаа.

Маршийн үеэр отолтын эсрэг ажиллагаа, дайсны хорлон сүйтгэх бүлгийг устгах, мөрдөн хөөх, тактикийн баримжаалал, тактикийн ажиллагаа, хордсон газар орныг туулах, амьд гарах

арга ухааны болон байр зүйн баримжааллыг зөв оновчтой хийх даалгавруудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн засвар хангалтын төвийн буудлагын полигонд офицер, ахлагч нарын бэлтгэлийн болон шалгалтын буудлагын дасгалуудыг боловсрууллаа.

Дэслэгч

С.СУВДАНЧИМЭГ



АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН АЛБА ХААГЧИД САЛБАРЫН ЖУУХ БИЧГЭЭР ШАГНАГДЛАА

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги



Тус ангийн Эрүүл мэндийн төвийн сувилагч А.Түвшинжаргал, Н.Мөнхжаргал нар нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах

үйлсэд идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, төр засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрээ үнэлүүлж, Эрүүл мэндийн сайдын


тушаалаар тус яамны "Жуух бичиг"-ээр шагнагдсаныг ангийн захирагч хурандаа У.Буянжаргал гардуулан өглөө.

ЦАХИМ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА

"Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт" сэдвээр цахим сургалтыг энэ сарын 14-ний

өдрөөс эхлүүлээ. Гурав хоногийн хугацаатай үргэлжлэх уг цахим сургалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

бариа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн мэдлэгийг олгож амжилттай төгссөн суралцагчдад "Сертификат" олгох юм.



"ХАЙРЫН ӨДӨР"-ӨӨР...

Ангийн сургалт, соёл хүмүүжлийн албанаас санаачлан 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдөр буюу Гэгээн хайрын өдрийг тохиолдуулан ангийн

байнгын бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдад "Хайртдаа хэлэх миний сэтгэлийн үг" сэдвээр захидал бичүүлж

ар гэрт нь хүргүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Ахлах дэслэгч
Б.ДОЛГОРСҮРЭН

